



**МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**

17060 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр,
Утас: 51-263051. Факс: (976) 7004-3479
E-mail: info@energy.gov.mn

дэдд. 05.06 № 2/1861
танай _____-ны № _____-т

Удирдамж өгөх тухай

“Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал:

1.Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг байгуулах тухай.

Хурлаас гарах шийдвэрт өгөх удирдамж:

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод байгуулах тухай асуудлыг хэлэлцэж, Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу дэд хороодыг байгуулах.



Н.ТАВИНБЭХ

170601103

"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар № 01

Улаанбаатар хот

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлан тэнцэлд өгсөн Төлөөлөн удирдах
зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.15 дахь заалтыг
үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дулаан шарын гол" Төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны үйл
ажиллагааны болон санхүүгийн тайлан тэнцлийн дүнг "Хангалттай" гэж үнэлсэн
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.


2. Компанийн 2021 оны үйл ажиллагаанд дүгнэлт хийж, зорилтот түвшинг
биелүүлэх, өртөг зардлыг бууруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, санхүү,
төлбөрийн чадварыг сайжруулах, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх шаардлагатай
арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /П.Даваадорж/-д
даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:




Б.НАСАНТОГТОХ



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:



Ц.БАЯР-ЭРДЭНЭ



"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар № 02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөл болон аудитын хорооны 2021 оны ажлын тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:


1. "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон аудитын хорооны 2021 оны үйл ажиллагааг "Хангалттай" гэж үзсүгэй.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн компанийн өмнө тавигдсан зорилтыг ханган биелүүлэх, өр авлагыг барагдуулах, бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу явуулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд хариуцлагатай, үр дүнтэй, санаачилгатай ажиллахыг тухай бүр нь анхааруулж байхыг Төлөөлөн удирдах зөвлөл /П.Даваадорж/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ


ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:

Б.НАСАНТОГТОХ



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар № 04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны
зардлын төсөв батлах тухай

"Компанийн тухай хууль"-ийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

1. "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг хавсралтын дагуу баталсугай.


2. Батлагдсан төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн
удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын болон Аудитын хороодод тус тус
даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ


ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:



“Дулаан шарын гол” ТӨХК-ийн Хувьцаа
 эзэмшигчдийн хурлын 2022 оны 04 дүгээр
 сарын 28 ны өдрийн 07 тоот тогтоолын
 хавсралт



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
 2021 ОНЫ ЗАРДАЛ

					/мян.төг/
№	Зардлын төрөл	Тоо	Нэгжийн зардал	Сар	Нийт зардал
1	ТУЗ-ийн дарга	1	550.0	12	6,600.0
	ТУЗ-ийн гишүүд	8	500.0	12	48,000.0
	Нарийн бичгийн дарга	1	450.0	12	5,400.0
	Цалингийн дүн				60,000.0
	ЭМ, НДШ /14.5%/	10	217.5	12	8,700.0
2	Бичиг хэргийн зардал				35,7
3	Шатахууны зардал				12,0
4	Томилолтын зардал				210,0
5	Хурлын зардал				480.0
6	ТУЗ-ын ярианы төлбөр				180.0
	НИЙТ ДҮН				69,360.0

"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар № 05

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын контрактыг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 84 дүгээр зүйлийн 84.4.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 345 дугаар тогтоолын 1.1, 2.1 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактыг дүгнэх, урамшуулал олгох түр журам"-ын 2.6, 2.7, 2.8, 2.9, 3.4 дэх хэсэг, Эрчим хүчний сайдын 2022 оны А/77 дугаар тушаалаар томилогдсон Ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Компанийн дүрмийн 8.10.5, 8.10.6 дахь заалт, гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын 3.1, 3.2 дахь хэсгийг хэрэгжүүлж ажилласан тул "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын 2021 оны контрактын биелэлтийг "Хангалттай" гэж дүгнэсүгэй.


2.Гүйцэтгэх захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг 1 /нэг/ жилийн хугацаатайгаар хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн шинэчлэн байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /П.Даваадорж/-д удирдамж болгосугай.

3.Засгийн газраас дэвшүүлсэн хэмнэлтийн бодлогод нийцүүлэн өртөг зардлыг бууруулах, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, өр, авлагыг барагдуулах, үр ашгийг дээшлүүлэх талаар удирдлага зохион байгуулалтын бодитой арга хэмжээ авч ажиллахыг гүйцэтгэх захирал /Б.Батхуяг/-д үүрэг болгосугай.


4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:


Б.НАСАНТОГТОХ
УХА0558

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:


Ц.БАЯР-ЭРДЭНЭ
6002169 11182000

"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар №06

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн
өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдийг
чөлөөлж, томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/5918 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй энэ тогтоолын нэгдүгээр хавсралтад нэр заасан гишүүдийг үргэлжлүүлэн ажиллуулахаар тогтоосугай.


2. "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй энэ тогтоолын хоёрдугаар хавсралтад нэр заасан гишүүдийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

3. "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх энэ тогтоолын гуравдугаар хавсралтад нэр заасан гишүүдийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн томилсугай.


4. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргаж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг судалж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ


ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:


Б.НАСАНТОГТОХ
УХА0558

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:


Ц.БАЯР-ЭРДЭНЭ
6002169 11102620


Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
06 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт



"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛД ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГИШҮҮНЭЭР
ҮРГЭЛЖЛҮҮЛЭН
АЖИЛЛАХ ГИШҮҮДИЙН НЭРС

№	Хуулийн этгээдийн нэр	Гишүүд
1		П.Даваадорж
2	" Дулаан шарын гол" төрийн өмчит	С.Ариунболд
3	хувьцаат компани	Н.Ган-Эрдэнэ


Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
06 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛД ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГИШҮҮНЭЭС
ЧӨЛӨӨЛӨГДӨХ ГИШҮҮДИЙН НЭРС

№	Хуулийн этгээдийн нэр	Гишүүн
1	" Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компани	Б.Нармандах
2		Г.Гэрэлт-Од
3		Б.Намжилжав

Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
06 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт



"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛД ТӨРИЙН ӨМЧИЙН ТӨЛӨӨЛӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГИШҮҮНЭЭР
ТОМИЛОГДОХ НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС

№	Хуулийн этгээдийн нэр	Гишүүн
1	" Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компани	Б.Дэлгэрэл
2		Д.Чимидлхам
3		Б.Бүжин

"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар №07

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус
гишүүдийг чөлөөлж, томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/5918 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус гишүүнээр ажиллаж буй энэ тогтоолын нэгдүгээр хавсралтад нэр заасан гишүүдийг үргэлжлүүлэн ажиллуулахаар тогтоосугай.

2."Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус гишүүнээр ажиллаж буй энэ тогтоолын хоёрдугаар хавсралтад нэр заасан гишүүдийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

3."Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус энэ тогтоолын гуравдугаар хавсралтад нэр заасан гишүүдийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн томилсугай.

4.Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргаж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг судалж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
ТӨЛӨӨЛӨГЧ


ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:



Б.НАСАНТОГТОХ

УХА0558


ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:



Ц.БАЯР-ЭРДЭНЭ

СНЗ0159 № 111826290


Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2022 оны 04 дүгээр сарын 22 ний өдрийн
07 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНЭЭР ҮРГЭЛЖЛҮҮЛЭН
АЖИЛЛАХ ГИШҮҮДИЙН НЭРС

№	Хуулийн этгээдийн нэр	Гишүүн
1	" Дулаан шарын гол " ТӨХК	Ш.Жавзансүрэн
2		Д.Оюунчимэг


Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2022 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн
07 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНЭЭС
ЧӨЛӨӨЛӨГДӨХ ГИШҮҮДИЙН НЭРС

№	Хуулийн этгээдийн нэр	Гишүүн
1	"Дулаан шарын гол" ТӨХК	Ч.Алтантуяа

Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
07 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт



"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНЭЭР ТОМИЛОГДОХ
НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС

№	Хуулийн этгээдийн нэр	Гишүүн
1	"Дулаан шарын гол" ТӨХК	Д.Цолмон